

**“НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,  
МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 4 сарын 10-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны хурлын тэмдэглэл:

**ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ :**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтад ирсэн материалыг танилцуулах тухай.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ :**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтад ирсэн материалыг танилцуулах тухай**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Энхтөр :**

Нэр дэвшүүлэх хорооны 1 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам, Компанийн дүрэмд заасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг тусган сонгон шалгаруулалтыг зарлаж 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүртэл дараах оролцогчийн материалыг хүлээн авсан.

1. Дамбачүлтэм овогтой Байлхүү

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК



*ТУЗ-ийн шинээр томилгодох хараат бус гишүүний танилцуулга*



Дамбачүлтэм **Байлхүү**, 1947.06.28



- Degree in of Economy, University of Mongolia, 1978-1982
- Trainee course of Price regulation, University of Maryland, USA, 1991
- Master of Economy, University of Mongolia, 1993
- Trainee course for Corporate Governance, University of Maryland, USA, 1994



- Монголд хувьчлал хийх анхны үзэл баримтлал 1990 он
- Засгийн газрын өмч хувчлалын хөтөлбөр 1991, 1992, 1997, 2000, 2004, 2008, 2014 он
- Өмч хувьчлалын хууль 1991 он
- Аж ахуйн нэгжийн тухай хууль 1991 он
- Компанийн менежмент, компанийн үйл ажиллагааг үнэлэх болон олон улсын нябо бүртгэлийн стандартыг нэвтэрүүлэх, аудит хийх анхны сургалтын төсөл НҮБ-ын UNESTRAL-тай хамт 1991-1992 он
- Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт төсөл, АХБ-тай хамт, 1992-2000 он
- Шудрага бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль 1993, 2000 он
- Нөхөрлөл, компанийн тухай хууль 1995 он
- Холбооны салбарыг хувьчлах өөрчлөн байгуулах төсөл, АХБ-тай хамт, 1993-1995 он
- Орон сууц хувьчлалын тухай хууль 1998 он



- Компанийн засаглалын гэрчилгээтэй



Д.Байлхүү нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж байна.

2. Очирбат овогтой Баярмагнай материалаа ирүүлсэн. О.Баярмагнай нь Монгол улсын хөгжлийн банкны Ди би Эм ассет менежмент ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2023 оноос одоог хүртэл ажиллаж байгаа нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг компанид хараат бус гишүүнээр ажиллаж байгаа нь ашиг сонирхолын болон бусад зөрчил үүсгэнэ хэмээн үзэж байгаа тул шаардлага хангахгүй байна гэж үзэж байна.

**Гишүүн Ж.Сандагсүрэн :**

Сонгон шалгаруулалтын ерөнхий шаардлагыг хангаж буй Д.Байлхүүг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгох саналтай байна.

### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ГИШҮҮДИЙН САНАЛ:**

**Гишүүн Ж.Сандагсүрэн:**

Саналыг дэмжиж байна.

**Гишүүн Б.Үүрцайхбаатар:**

Саналыг дэмжиж байна.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

**Гишүүн Ж.Сандагсүрэн :**

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн Нэр дэвшүүлэх хорооноос Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд Дамбачүлтэм овогтой Байлхүүг олонхын саналаар дэмжлээ.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн ерөнхий шаардлагыг хангасан Дамбачүлтэм овогтой Байлхүүг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхээр болов.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ГИШҮҮД :**

Ж.САНДАГСҮРЭН



Б.ҮҮРЦАЙХБААТАР

**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

Д.ЭНХТӨР

